

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 26.4 дэх хэсэг нэмсүгэй:

26 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“26.4.энэ хуулийн 26.2-т зааснаас бусад малыг гадаадад гаргах лиценз олгоход малын тоо толгой тутмаас дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

26.4.1. адуу 48 000-120 000 төгрөг;

26.4.2. үхэр 32 000-80 000 төгрөг;

26.4.3. хонь 19 200-48 000 төгрөг;

26.4.4. ямаа 19 200-48 000 төгрөг;

26.4.5. тэмээ 96 000-240 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “26.3” гэсний дараа “26.4” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/26 дугаар зүйлийн 26.3.2 дахь заалт:

“26.3.2. малын үржүүлгийн бусад бүтээгдэхүүн 5 000-50 000 төгрөг;”

2/35 дугаар зүйлийн 35.1.21 дэх заалт:

“35.1.21. малын удам гарвацийн болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийн гэрчилгээ, мал, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгоход 1000-5000 төгрөг.”

4 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.9 дэх заалтын “малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, үржлийн сайжруулагч мал импортлох, экспортлох” гэснийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.11.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн зүйлийн 26.3 дахь хэсгийн “гүн хөлдөөсөн үр, хөврөл үр” гэснийг “үржүүлгийн бүтээгдэхүүнийг” гэж, “гаргахад” гэснийг “гаргах лиценз олгоход” гэж, мөн зүйлийн 26.3.1 дэх заалтын “гүн хөлдөөсөн үр, хөврөл үр” гэснийг “үр, хөврөл” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.19, 35.1.20 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ